



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

“Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.20, 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар”-ыг, 2008 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар”-ыг, 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА  БАТБОЛД



Санхүүгийн зохицуулах хорооны
2016 оны 03 дугаар сарын 04 ний өдрийн
№ 2 дугаар тогтоолын хавсралт

**ДААТГАЛ ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ДААТГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ДААТГАГЧ ДАГАЖ
МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Даатгалын тухай хуульд заасны дагуу даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлох, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-д тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлттэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ.

1.3. Даатгалын тухай хуулийн 16.1 дэх заалтын дагуу дор дурдсанаас бусад этгээд Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид Хороо гэх) олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

1.3.1. Даатгалын тухай хуулийн 4.1.2-т заасан даатгагчтай гэрээ байгуулан давхар даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд;

1.3.2. Даатгалын тухай хуулийн 17.2 дахь заалтад заасан зөвшөөрөл авсан гадаад улсын даатгагч;

Хоёр. Нэр томьёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “даатгалын гэрээ байгуулах эрхтэй этгээд” гэж даатгалын компанийн орон тооны ажилтан, даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгчийг ойлгоно.

2.1.2. “даатгалын гэрээ эзэмшигч” /policyholder/ гэж даатгагчтай байгуулах даатгалын гэрээнд гарын үсэг зурсан этгээдийг ойлгоно.

2.1.3. “бенефишер” гэж ашиг сонирхол нь даатгагдсан этгээдийг ойлгоно.

Гурав. Даатгалын үйл ажиллагаа

3.1. “Даатгалын үйл ажиллагаа” гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг ойлгоно. Даатгалын гэрээний хугацаа даатгуулагчидтай харилцан тохиролцсон хугацаагаар үргэлжилнэ.

3.2. Даатгагч ердийн даатгалын болон урт хугацааны даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа давхар эрхлэхийг хориглоно.

3.3. Даатгалын үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хамааруулна:

3.3.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон даатгагч даатгалын хэлбэрт хамаарагдах даатгалын бүтээгдэхүүний гэрээ болон даатгалын баталгаа боловсруулж гаргах;

3.3.2. Монгол Улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд заасны дагуу даатгалын гэрээ байгуулах, гэрээг сунгах, өөрчлөх;

3.3.3. Даатгалын гэрээг бусдад шилжүүлэх, цуцлах;

3.3.4. Даатгалын тухай хууль, даатгалын гэрээнд заасны дагуу даатгалын нөхөн төлбөр төлөх;

3.3.5. Даатгалын эрсдэлийн болон хохирлын тойм үнэлгээ, судалгаа хийх;

3.3.6. Хорооноос баталсан журмын дагуу даатгалын нөөц сан байгуулах, хуваарилах;

- 3.3.7. Даатгалын хураамжийн тооцоолол түүнтэй холбоотой аливаа судалгаа хийх;
- 3.3.8. Даатгалын үйл ажиллагааны журам заавар, даатгалын бүтээгдэхүүний гэрээ боловсруулах түүнийг эзэмших;
- 3.3.9. Даатгагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээ гаргах зэрэгтэй холбоотой даатгалын үйл ажиллагаа явуулах;
- 3.3.10. Даатгалын салбар, төлөөлөгчийн газар нээж, ажиллуулах;

Дөрөв. Даатгалтай холбоотой үйл ажиллагаа

- 4.1. Даатгагчийн дараах үйл ажиллагааг даатгалтай холбоотой үйл ажиллагаанд хамааруулна:
 - 4.1.1. Хорооноос баталсан журамд заасан нэр төрөл, хувь хэмжээний хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа;
 - 4.1.2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдах, хөрөнгийг захиран зарцуулах;
 - 4.1.3. Даатгалын эрсдэлээ давхар даатгуулах, түүнтэй холбоотой үүсч болох бусад үйл ажиллагаа явуулах;
 - 4.1.4. Даатгалын зөвлөгөө, сургалт явуулах;
 - 4.1.5. Даатгагчийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулах;
 - 4.1.6. Даатгагчийн компанийн байрны засвар үйлчилгээ хийх, түүнийг худалдах, худалдан авах;
 - 4.1.7. Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлд зааснаас бусад даатгалын зар сурталчилгаа явуулах;
 - 4.1.8. Даатгагч хоорондын даатгалын гэрээ шилжүүлэх үйл ажиллагаа.
 - 4.1.9. Холбогдох хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа эрхлэх.
- 4.2. Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн албан журмын даатгалын үйл ажиллагаа, даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа, даатгалын аудитын үйл ажиллагаа нь даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарахгүй.

Тав. Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

- 5.1. Даатгагч нь үйл ажиллагаандаа дараах шаардлагыг байнга хангаж ажиллана:
 - 5.1.1. Даатгалын тухай хууль холбогдох бусад хууль тогтоомж болон даатгалын багц дүрмийг дагаж мөрдөх;
 - 5.1.2. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх;
 - 5.1.3. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах техник тоног төхөөрөмж, даатгал, санхүү, бүртгэлийн программ хангамжтай байх;
 - 5.1.4. Компанийн бүтэц дотор даатгалын тохиолдлыг газар дээр нь шалгаж баталгаажуулах, даатгуулагчийн нөхөн төлбөр, өргөдөл, гомдлыг барагдуулдаг, эрх ашгийг нь хамгаалдаг нэгжтэй байх;
 - 5.1.5. Даатгагч нь компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон давхар даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын нэгж, эсхүл албан тушаалтантай байх. Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсан дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаанд мөрдөх журамтай байх;
 - 5.1.6. Компаниас гарсан шийдвэр болон компанийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх дотоод журам, заавар, нягтлан бодох бүртгэлийн, даатгалын баримт бичгийг архивлан хадгалах;
 - 5.1.7. Даатгагч нь өөрийн хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл болон түүнд орсон өөрчлөлтийн талаар хувийн хэрэг /хавтаст материал/ үүсгэн хадгалах;
 - 5.1.8. Даатгагч нь хаяг, холбоо барих утас, даатгалын бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулгыг мэдээлсэн өөрийн цахим хуудастай байх, эдгээрт өөрчлөлт ороход Хороонд мэдэгдэх;

5.1.9. Даатгагч нь санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор томилсон аудитортой байх бөгөөд даатгагч аудиторыг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэж байх;

5.1.10. Хорооны тогтоолоор батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-д заасан шаардлагыг хангасан актуарчтай байх;

5.1.11. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан давхар даатгалын жилийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацааны дотор Хороонд ирүүлж байх;

5.1.12. Даатгагч нь банкны өөрийн дансны гүйлгээг хянуулах болон шалгуулах нөхцөл, шаардлагыг хангасан байх;

5.1.13. Даатгалын компани нь нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

5.1.14. Тус журмын 5.1.19-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх;

5.1.15. Даатгалын компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах мөн Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн governance.mn цахим хуудаст мэдээллийг ил тод гаргаж байх;

5.1.16. Даатгагч нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, хувьцаат компани, гадаадын хөрөнгө оруулалттай компанитай гэрээ байгуулсных нь төлөө даатгалын төлөөлөгчид олгосон төлбөр, хөлс, даатгуулагч, даатгалын гэрээний талаарх мэдээллийг энэ журмын хавсралтын дагуу гарган улирал бүрийн тайлангийн хамт Хороонд ирүүлж, дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор өөрийн цахим хуудсанд олон нийтэд ил тод зарлан мэдээлэх;

5.1.17. Даатгагч цахим хэлбэрээр хийх даатгалын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, заавар, аргачлалыг боловсруулж өөрийн цахим хуудаст байршуулах;

5.1.18. Даатгагч даатгуулагчийг өөрийн цахим хуудаст орж даатгуулах боломжийг энгийн нөхцөл байдлаар бүрдүүлсэн байх;

5.1.19. Даатгагч цахимаар хэлбэрээр хийх даатгалын бүтээгдэхүүний тухай Хороонд мэдэгдэх, өөрийн цахим хуудаст бүтээгдэхүүний нэрсийг тодорхой зааж, тухайн даатгалын бүтээгдэхүүний гэрээг байршуулах, мөн даатгалын хураамж төлөх банк, дансны дугаарыг тодорхой зааж өгсөн байх;

5.1.20. Цахим хэлбэрээр хийгдэж байгаа даатгалын бүтээгдэхүүний мэдээллийг нэгтгэх, мөн судалгаа хийх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх;

5.1.21. Цахим хэлбэрээр даатгал хийлгэсэн даатгуулагчид өөрийн даатгалын гэрээ болон холбогдох мэдээллээ хянах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн байх;

5.1.22. Даатгагч цахим даатгалын үйл ажиллагааны программ хангамж, системийн аюулгүй найдвартай ажиллагааг хангаж ажилласан байх;

5.1.23. Цахим хэлбэрээр хийгдсэн даатгалын гэрээний хураамжийн орлогоос аливаа нэг урамшуулал болон даатгалын орлогын шимтгэл олгохгүй;

5.1.24. Даатгагч холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах.

5.1.25. Даатгагчийн эрх бүхий албан тушаалтан нь Хорооны тогтоолоор батлагдсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-г заасан шаардлагыг хангасан байх;

5.1.26. Даатгалын үйл ажиллагаатай холбогдсон шаардлагатай мэдээллийг Хороонд ирүүлдэг байх;

5.1.27. Даатгагчийн даатгалын гэрээ байгуулах эрхтэй этгээд нь 2 жил тутамд зохион байгуулсан даатгалын сургалтад хамрагдсан байна.

5.1.28. Даатгагч нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлсэн хөлс, төлбөрийг арилжааны банк дахь даатгалын төлөөлөгчийн дансанд бэлэн бусаар шилжүүлэн олгоно.

5.1.29. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлээгүй даатгалын төлөөлөгчид аливаа хөлс, төлбөр төлөхийг хориглоно.

5.2. Даатгагчийн даатгалын бүтээгдэхүүн дараах шаардлагыг хангасан байна:

5.2.1. Даатгагч орон сууцны урт хугацааны зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг даатгахдаа Монголбанкнаас баталсан ипотек (моргэйж)-ийн зээлийн холбогдох журамд заасан зээл авах шаардлагыг хангаагүй зээл хүсэгчийг даатгахгүй байх;

5.2.2. Зээлдэгчийн амь насны даатгалын гэрээний хугацаа нь зээлийн гэрээний хугацаанаас багагүй байх;

5.2.3 Зээлдэгчийн амь насны даатгалын хувьд даатгагч урт хугацааны нөөц байгуулах;

5.2.4. Даатгагч нь банкны орон сууцны зээлийн нөхцөл, шаардлагад өөрчлөлт орсон эсхийг судалсан байх;

5.2.5. Орон сууцны урт хугацааны зээл (моргэйж, ипотек)-ийн хөрөнгийн даатгалын бүтээгдэхүүнийг борлуулахдаа эрсдэлийг тараах зорилгоор нэг байршилд буй хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь тухайн даатгагчийн нөөцийн сангийн хөрөнгөөс давсан тохиолдолд нэг даатгагч дангаараа даатгахыг хориглоно.

5.2.6. Даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтан нь өөр даатгагчийн эрх бүхий албан тушаалтнаар ажиллахыг хориглоно.

5.2.7. Даатгалын бүтээгдэхүүний эрсдэл нь хураамжийн хувь хэмжээтэй уялдаатай байх

5.2.8. Цахим хэлбэрээр хийгдсэн даатгалын бүтээгдэхүүний гэрээний хүчин төгөлдөр болох нөхцөл, хугацааг тодорхой зааж өгөх;

5.2.9. Даатгалын бүтээгдэхүүн нь төрөл, хэлбэрээсээ хамааран Хорооны тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д заасан шаардлагыг хангаж байх.

5.2.10. Даатгагч цахим хэлбэрээр хийгдсэн даатгалын гэрээний баталгааг даатгуулагчийн цахим хаягаар ажлын 3 хоногийн дотор хүргүүлэх;

Зургаа. Даатгагчийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд тавигдах шаардлага

6.1. Даатгалын компанийн салбар нь зөвхөн тухайн даатгалын байгууллагын оноосон нэрийг хэрэглэх ба салбарын эрхлэх үйл ажиллагааны хүрээ, ажиллах журмыг даатгалын компани өөрөө тогтооно.

6.2. Даатгалын компанийн салбар нь Хорооны тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

6.3. Улаанбаатар хот дахь салбарын захирал таван зуун мянган төгрөг хүртэл, хөдөө орон нутаг дахь салбарын захирал гурван зуун мянган төгрөг хүртэл дүнтэй нөхөн төлбөрийг бие даан шуурхай шийдвэрлэдэг байх;

6.4. Салбар нь сүүлийн 2 жилийн санхүүгийн болон даатгалын анхан шатны баримтууд, хохирлын нөхөн төлбөрийн материалууд, мөн салбарын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивлан хадгалж байх;

6.5. Салбар нь Хорооны тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын журмын дагуу гаргасан тайлан мэдээг улирал бүр Санхүүгийн зохицуулах хорооны аймаг, нийслэл, дүүрэг дэх орон нутгийн төлөөлөгчид хүргүүлж байх;

6.6. Даатгалын төлөөлөгчийн газар нь Хорооны тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

6.7. Гадаад улсад үйл ажиллагаа эрхэлдэг даатгагчийн салбар нь “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

Долоо. Даатгалын гэрээ байгуулах болон даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаанд тавигдах шаардлага

7.1. Даатгалын гэрээ байгуулахад дараах шаардлага тавигдана:

7.1.1. Даатгуулагчтай байгуулж байгаа даатгалын гэрээ нь монгол хэл дээр үйлдэгдсэн, утга санаа, үг хэллэг нь ойлгомжтой, төөрөгдүүлсэн болон хоёрдмол санаа агуулаагүй байх, даатгуулагчийн хүсэлтээр гадаад хэл дээр даатгалын гэрээ байгуулж байгаа тохиолдолд монгол хэл дээр тухайн даатгалын гэрээг давхар үйлдэх, маргаан гарсан нөхцөлд монгол хэл дээр хийгдсэн гэрээг баримтлах;

7.1.2. Даатгалын гэрээнд даатгалын эрсдэл болон нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг хоёрдмол утгагүй тодорхой зааж тусгах;

7.1.3. Даатгалын гэрээ дуусгавар болох хугацаанаас өмнө даатгалын гэрээ цуцлагдсан тохиолдолд даатгалын хураамжийн буцаалтыг даатгуулагч бичгээр хүсэлт гаргаснаас хойш 7 хоногийн дотор даатгуулагчид олгох;

7.1.4. Бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулах / даатгалын гэрээнд ажилтнуудыг ажил олгогч төлөөлж, оршин суугчдыг сууц өмчлөгчдийн холбоо төлөөлж гэх мэт/ тохиолдолд тухайн бүлэгт хамаарах даатгуулагч бүрд Иргэний тухай хуулийн 433.1-т заасны дагуу даатгагчаас гарын үсэг зурсан даатгалын баталгааг гардуулах үүрэгтэй.

7.1.5. Даатгалын баталгаанд даатгуулагчийн овог, нэр, нас, хүйс, даатгалын эрсдэл, нөхөн төлбөрийн нөхцөл, хасалт, даатгалын хураамж, даатгалын үнэлгээ, даатгагчийн хаяг, холбоо барих утсыг заавал тусгасан байна.

7.1.6. Даатгагч эсхүл түүний төлөөлөгч нь бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгуулагч нэг бүрт тухайн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулж, зөвшөөрлийг бичгээр авсан байна.

7.1.7. Даатгалын гэрээнд даатгагч, даатгуулагчийн эрх үүрэг, даатгалын эрсдэл, даатгалын үнэлгээ, гэрээний эхлэх дуусгах хугацаа, гэрээг сунгах, цуцлах, өөрчлөлт оруулах нөхцөл, даатгалын хураамжийн хэмжээ, хураамж төлөх хугацаа, даатгалын гэрээ ямар нөхцөлд хүчин төгөлдөр бус болох зэргийг тодорхой зааж тусгасан байна.

7.1.8. Даатгуулагч нь даатгалын гэрээ байгуулахын тулд бүлэг байгуулахыг хориглоно.

7.1.9. Даатгуулагч нь хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө даатгагчаас хүлээн авч буй төлбөр, хөлсний талаар даатгалын төлөөлөгч нь даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө даатгуулагчид бичгээр мэдэгдэж, төлбөр, хөлсийг даатгалын төлөөлөгчид олгохыг зөвшөөрсөн даатгуулагчийн гарын үсэг бүхий мэдэгдлийг даатгагчид хүргүүлээгүй, даатгалын төлөөлөгчид аливаа төлбөр, хөлс төлөх, өөрийн нэрийн өмнөөс даатгалын гэрээг байгуулах эрх олгохыг хориглоно.

7.1.10. Даатгагч даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулахдаа даатгалын гэрээ байгуулах эрхтэй /тусгай зөвшөөрөл/ этгээдээр дамжуулж гэрээ байгуулна.

7.2. Даатгалын нөхөн төлбөр олгоход дараах шаардлага тавигдана:

7.2.1. Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгоходоо даатгуулагчийг чирэгдүүлэхгүй байх;

7.2.2. Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах, хасалт хийх нөхцөл бүхий заалтыг даатгалын гэрээнд тусгасан тохиолдолд татгалзах үндэслэл, хасалт хийх нөхцөл нь Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн аль зүйл, заалтад хамааралтай болох тухай тайлбарыг Хороонд ирүүлж хянуулах;

7.2.3. Даатгагч хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг даатгуулагчаас шаардах тохиолдолд уг дүгнэлт гараагүй байхад даатгалын гэрээнд заасан хугацаа өнгөрсөн шалтгаанаар даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзахыг хориглоно.

7.2.4. Даатгагч даатгуулагч харилцан тохиролцож даатгалын гэрээнд заасны дагуу даатгалын хураамжийг хэсэгчлэн, үе шаттай төлж байгаа үед даатгалын тохиолдол учирвал даатгагч даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчийн төлсөн хураамжтай хувь тэнцүүлэн бууруулахыг хориглоно;

7.2.5. Даатгалын гэрээнд заасан болон мөн сунгасан хугацаанд даатгалын хураамж төлөгдөөгүй нөхцөлд журмын дээрх 7.2.4 дэх заалт хамаарахгүй.

7.2.6. Урт хугацааны даатгалын гэрээ эзэмших эрх бүхий этгээд тухайн гэрээнд заагдсан даатгалын бенефишерт гэрээний эрхийн талаар бичгээр мэдэгдэх бөгөөд бенефишер байхгүй,

эсхүл энэ эрхээс татгалзсан, эсхүл нас барсан тохиолдолд даатгалын гэрээ эзэмшигчийн хууль ёсны өв залгамжлагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

7.3. Ердийн даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохдоо дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.3.1. Даатгагч даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг авсан даруйдаа даатгуулагчид хариу өгч, даатгуулагчаас авах арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд даатгагч 72 цагийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж баримтжуулах өөрийн ажилтанг эсхүл даатгалын хохирол үнэлэгчийг томилно.

7.3.2. Даатгалын хохирлын үнэлгээний тайланг баталгаажуулж ирүүлснээс хойш даатгагч 14 хоногийн дотор багтаан даатгалын нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг шийдвэрлэж даатгуулагчид бичгээр мэдэгдэх бөгөөд даатгалын нөхөн төлбөрийг олгосон байна.

7.4. Урт хугацааны даатгагч нөхөн төлбөр олгохдоо дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.4.1. Урт хугацааны даатгалын компани даатгалын тохиолдлын нэхэмжлэл авсан даруйдаа бүртгэж, 7 хоногийн дотор даатгуулагчаас нэмэлт материалыг багцаар нь шаардаж болно.

7.4.2. Шаардагдах бүх материалыг авсанаас хойш 30 хоногт багтаан нэхэмжлэлийг барагдуулах эсхүл олгохгүй байх нөхцөл шалтгааныг дурдаж даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

7.4.3. Даатгагч даатгалын гэрээ болон холбогдох журамд заасан хугацаанд даатгалын нөхөн төлбөр олгоогүй бол Иргэний хуулийн 232.6 дахь хэсэгт заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцох заалтыг даатгалын гэрээнд тусгасан байна.

7.4.4. Энэ журмын 7.3.1-7.4.3 дахь заалт нь Жолоочийн албан журмын даатгалд хамаарахгүй

7.4.5. Аливаа этгээдээс даатгалын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн гомдол, гарсан маргааныг шийдвэрлэсэн Хорооны шийдвэрийг эс зөвшөөрч, Даатгалын тухай хуулийн 82.1-д заасны дагуу гомдол гаргаагүй тохиолдолд даатгагч Хорооны шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

7.4.6. Даатгагч энэ журмын 7.4.5. дахь заалтыг биелүүлээгүй нь Даатгалын тухай хуулийн 67.1.1, 68 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээ авах үндэслэл болно.

Найм. Хяналт, хариуцлага


8.1. “Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-д Хорооны Ажлын алба хяналт тавьж ажиллана.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- ооОоо ---

Санхүүгийн зохицуулах хорооны
2016 оны 23 дугаар сарын 27-ний өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт

**ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ОЛГОСОН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН
ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**



д/д	20 ... оны улирал	Даатгалын төлөөлөгчийн нэр	Даатгуулагчийн нэр ¹	Байгууллагын төрөл ²	Даатгалын хураамжийн орлогын шимтгэлийн дүн ³

1 Даатгуулагчийн нэрийг товчлолгүйгээр бүрэн бичнэ. 2 Байгууллагын төрлөөр дараах дугаарыг бичнэ: Төрийн байгууллага -1, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж -2, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж -3, Хувьцаат компани – 4, Гадаадын хөрөнгө оруулалттай компани – 5. Хэрвээ байгууллагын төрөл давхцсан тохиолдолд дугааруудыг хамтад нь бичнэ. 3 Тухайн улиралд даатгуулагчтай байгуулсан нийт гэрээний орлогоос олсон шимтгэлийн дүнг бичнэ.